



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/51

Булган сум

**Хүндэтгэл үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 30 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хошой аварга малчин, Улсын аварга малчин, Улсын аварга саальчин, Улсын аварга тариаланч, Улсын аварга тариаланч хамт олноор шалгарсан дараах малчин, тариаланчдад хүндэтгэл үзүүлсүгэй.

“Улсын хошой аварга малчин өрх”-өөр:

- Баян-Агт сумын Халтар багийн малчин Дүгэржавын Галбадрах,
- Хишиг-Өндөр сумын Хүрэмт багийн малчин Баатарын Батбаяр.

“Улсын аварга малчин өрх”-өөр:

- Хутаг-Өндөр сумын Уньт багийн малчин Нямдоржийн Ундрах,
- Гурванбулаг сумын Агьт багийн малчин Пүрэвийн Шижирболд,
- Дашинчилэн сумын Лах багийн малчин Сандагийн Баяржаргал,
- Баян-Агт сумын Дулаанхаан багийн малчин Батцэрэнгийн Ууганбаяр,
- Сайхан сумын Мануулт багийн малчин Жалбаагийн Мөнхсайхан,
- Орхон сумын Мааньт багийн малчин Дагвасамбуугийн Алтанхүү,
- Хангал сумын Сөрт багийн малчин Өсөхбаярын Гомбодорж,
- Рашаант сумын Аргалхайрхан багийн малчин Мангалжавын Нямхүү,
- Могод сумын Баянгол багийн малчин Баатарын Мөнхжаргал,
- Бүрэгхангай сумын Бумбат багийн малчин Балжиннямын Нансал;

“Улсын аварга саальчин”-аар:

- Сайхан сумын Ундрах багийн саальчин Мягмарсүрэнгийн Оюунцэцэг.

“Улсын аварга тариаланч”-аар:

- Хутаг-Өндөр сумын “Эг тариа” ХХК-ийн механикжуулагч Санжаагийн Болдбаатар,
- Хутаг-Өндөр сумын иргэн Батдорлигийн Мөнх-Од,
- Хангал сумын “Молор Эрдэнэ түрүү” ХХК-ийн механикжуулагч Юнгэрэнийн Батцэнгэл,

- Сэлэнгэ сумын “Интосэ” ХХК-ийн механикжуулагч Должинсүрэнгийн Эрдэнэцогт

“Улсын аварга тариаланч хамт олон”-оор:


- Рашаант сумын “Ти Эн Эс Эн Ти” ХХК;
- Тэшиг сумын “Илэнхэн” ХХК;

2.Хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталж, шаардагдах 22,169,340 (хорин хоёр сая нэг зуун жаран есөн мянга гурван зуун дөч) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны  
02 дугаар сарын 05 ны өдрийн А/С/1 дугаар  
захирамжийн хавсралт



**ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХЭД ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

<b>Д/д</b>	<b>Нэр төрөл</b>	<b>Тоо ширхэг</b>	<b>Нэгжийн үнэ (мян.төг)</b>	<b>Бүгд үнэ (мян.төг)</b>
<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>
1	Талархал	19 ш	100,000	1,900,000
2	Гарын бэлэг	19 ш	742,200	14,100,000
3	Шатахууны зардал	549 л	3950	6,169,340
	<b>Бүгд</b>			<b>22,169,340</b>